УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сагил сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2022/171/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаангом хот 2022 он	Увс аймаг дахь Төрийн аудитын газар, Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn Аудитын менежер: М.Бат-Амгалан Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn Аудитор: Т.Амармэнд Утас: 70453721, Цахим хаяг: amarmendt@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт 2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл 4
3. Аудитын тайлан 14
3.1 Ерөнхий зүйл 14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт 14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал 15
3.4 Материаллаг байдал 15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга 15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв 16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг 17
3.8 Аудитын гол асуудал 17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал 17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт 18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал 18
4. Аудитын илрүүлэлт 18
4.1 Залруулсан алдаа 18
5.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл 19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

САГИЛ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГА Н.НАСАНЖАРГАЛ
ТАНАА

2022.02.25 № УВА-2022/171/НА-СТА-ТШЗ
танай_____-ны №_____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сагил сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Сагил сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Сагил сумын Эрүүл мэндийн төв нь 162.2 мянган төгрөгийн сахилгын шитгэлийн өглөгийг цалингийн зардлаас шилжүүлсэн, хүнсний материалын тооллогоор 495.0 мянган төгрөгийн 55 кг мах дутагдсан, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны 377/А99 дүгээр тушаалыг зөрчин Ковид-19 цар тахлын холбогдуулан олгосон санхүүжилтээс 49,600.0 мянган төгрөгийн мөнгөн тэтгэмж олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.2 дахь хэсэгт "Албаны эрх мэдлээ хэтрүүлэх;" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй нь "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

0200200479

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.БАТСУУРЬ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	**ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН**	**20,746,472.00**	**223,977,716.27**
31	**МӨНГӨН ХӨРӨНГӨ**	00.00	23,158,947.57
311	**Кассанд байгаа бэлэн мөнгө**	00.00	00.00
312	**Банкинд байгаа бэлэн мөнгө**	00.00	23,158,947.57
3121	**Төгрөг**	00.00	23,158,947.57
31211	Төрийн сангийн харилцах	00.00	10,171,694.57
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	00.00	12,987,253.00
33	**АВЛАГА**	493,000.00	160,069,100.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	00.00	160,069,100.00
335	**Бусад авлага**	493,000.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	493,000.00	00.00
35	**БАРАА МАТЕРИАЛ**	20,253,472.00	40,749,668.70
351	**Түүхий эд материал**	6,856,774.00	18,959,273.50
35110	Тусгай зориулалттай материал	165,000.00	165,000.00
35130	Эм боох материал	6,691,774.00	18,794,273.50
354	**Хангамжийн материал**	13,076,698.00	21,470,395.20
35410	Бичиг хэргийн материал	510,000.00	871,750.00
35420	Аж ахуйн материал	11,332,428.00	16,586,205.20
35430	Сэлбэг хэрэгсэл	675,000.00	657,600.00
35460	Хүнсний материал	559,270.00	3,354,840.00
35600	Мал амьтад	320,000.00	320,000.00
2	**ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН**	**460,282,402.59**	**897,545,425.40**
39	**ҮНДСЭН ХӨРӨНГӨ**	460,282,402.59	897,545,425.40
392	**Биет хөрөнгө**	453,400,402.59	890,723,425.40
39201	Барилга, байгууламж, орон сууц	365,593,834.00	763,643,341.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-19,269,034.44	-26,826,284.84
39203	Авто-тээврийн хэрэгсэл	80,711,833.00	100,760,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-27,202,180.17	-20,415,555.71
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	87,877,545.50	120,675,031.31
39206	Хуримтлагдсан элэгдэл	-58,106,628.77	-65,180,914.94
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	38,674,806.16	37,916,300.16
39208	Хуримтлагдсан элэгдэл	-14,879,772.69	-19,848,491.58
39214	Бусад үндсэн хөрөнгө	377,120.00	377,120.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-377,120.00	-377,120.00
393	**Биет бус хөрөнгө**	6,882,000.00	6,822,000.00
39301	Програм хангамж	740,000.00	740,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-500,000.00	-560,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	6,642,000.00	6,642,000.00
3	**НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II**	**481,028,874.59**	**1,121,523,141.67**
4	**НИЙТ ӨР ТӨЛБӨР**	**162,204.00**	**302,245.00**
41	**БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР**	162,204.00	302,245.00
413	**Өглөг**	162,204.00	302,245.00

41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	23,461.00
4136	**Бусад өглөг**	162,204.00	278,784.00
41361	Байгууллагад төлөх өглөг	162,204.00	278,784.00
5	**ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН**	**480,866,670.59**	**1,121,220,896.67**
51	**Засгийн газрын хувь оролцоо**	480,866,670.59	1,121,220,896.67
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	216,844,280.85	216,844,280.85
51101	Өмч: - төрийн	216,844,280.85	216,844,280.85
512	**Хуримтлагдсан үр дүн**	93,133,991.43	733,488,217.52
51210	Өмнөх үеийн үр дүн	93,133,991.43	93,140,954.18
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	640,354,226.09
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	170,888,398.31	170,888,398.31
6	**ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V**	**481,028,874.59**	**1,121,523,141.67**

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)**	**483,636,250.00**	**1,348,690,343.26**
11	**ТАТВАРЫН ОРЛОГО**	**00.00**	**00.00**
12	**ТАТВАРЫН БУС ОРЛОГО**	**68,065,000.00**	**490,269,763.26**
120	**Нийтлэг татварын бус орлого**	68,065,000.00	490,269,763.26
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	68,065,000.00	490,269,763.26
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	68,065,000.00	490,269,763.26
13	**ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО**	**70,356,850.00**	**445,494,080.00**
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	345,214,400.00	412,926,500.00
1311	**Нэмэлт санхүүжилтийн орлого**	24,893,500.00	232,337,200.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	9,389,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	24,893,500.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	222,948,200.00
1320	**Орон нутгийн төсвөөс санхүүжих**	26,563,500.00	34,185,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	26,563,500.00	34,185,200.00
1340	**Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих**	18,899,850.00	178,971,680.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	18,899,850.00	178,971,680.00
2	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН**	**442,630,314.13**	**699,412,832.98**
21	**УРСГАЛ ЗАРДАЛ**	**442,630,314.13**	**699,412,832.98**
210	**БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ**	440,251,501.58	666,637,432.98
2101	**Цалин хөлс болон нэмэгдэл урамшил**	282,774,298.00	402,618,064.66
210101	Үндсэн цалин	258,830,706.00	292,576,499.66
210102	Нэмэгдэл	00.00	75,888,624.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	5,177,250.00
210104	Урамшуулал	18,903,592.00	23,935,691.00
210105	Гэрээт ажлын хөлс	5,040,000.00	5,040,000.00
2102	**Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл**	35,764,948.45	48,633,255.27
210201	Тэтгэврийн даатгал	24,407,849.65	37,793,805.90
210202	Тэтгэмжийн даатгал	2,839,299.83	2,889,346.40
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,271,399.88	2,311,928.93
210204	Ажилгүйдлийн даатгал	567,799.09	570,069.42
210205	Эрүүл мэндийн даатгал	5,678,600.00	5,068,104.62
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
2103	**Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал**	24,843,954.00	32,544,495.00
210301	Гэрэл, цахилгаан	1,825,809.00	3,479,327.00
210302	Түлш, халаалт	22,968,145.00	29,065,168.00
210303	Цэвэр, бохир ус	50,000.00	00.00

2104	**Хангамж, бараа материалын зардал**	21,985,270.00	31,156,980.00
210401	Бичиг хэрэг	2,294,800.00	2,292,650.00
210402	Тээвэр, шатахуун	14,636,750.00	21,374,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,335,220.00	1,798,030.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	696,000.00	1,504,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,022,500.00	4,187,500.00
2105	**Норматив зардал**	29,629,683.00	112,510,754.50
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	23,222,503.00	97,580,384.50
210502	Хоол, хүнс	6,407,180.00	14,480,370.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	450,000.00
2106	**Эд хогшил, урсгал засварын зардал**	3,697,900.00	450,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,149,400.00	00.00
210604	Урсгал засвар	2,548,500.00	450,000.00
2107	**Томилолт, зочны зардал**	98,000.00	192,000.00
210702	Дотоод албан томилолт	98,000.00	192,000.00
2108	**Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж**	569,326.00	937,284.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	30,400.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	120,000.00	216,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	54,450.00	79,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	77,500.00	100,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	00.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	264,000.00	308,000.00
210807	Газрын төлбөр	22,976.00	178,784.00
2109	**Бараа үйлчилгээний бусад зардал**	40,888,122.13	37,594,599.55
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,862,500.00	1,614,950.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	25,025,622.13	35,979,649.55
213	**УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ**	2,378,812.55	32,775,400.00
2132	**Бусад урсгал шилжүүлэг**	00.00	31,800,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	31,800,000.00
2133	**Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг**	2,378,812.55	975,400.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,378,812.55	975,400.00
3	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)**	**41,005,935.87**	**649,277,510.28**
145	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН**	00.00	00.00
225	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН**	00.00	8,923,284.19
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	8,923,284.19
4	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)**	00.00	-8,923,284.19
5	**НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)**	**41,005,935.87**	**640,354,226.09**

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)**	**415,571,250.00**	**698,351,480.00**
11	**ТАТВАРЫН ОРЛОГО**	**00.00**	**00.00**
13	**ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО**	**415,571,250.00**	**698,351,480.00**
1310	**Улсын төвлөрсөн төсвөөс**	00.00	00.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	345,214,400.00	412,926,500.00
1311	**Нэмэлт санхүүжилтийн орлого**	24,893,500.00	232,337,200.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	9,389,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	24,893,500.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	222,948,200.00
1320	**Орон нутгийн төсвөөс санхүүжих**	26,563,500.00	34,185,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	26,563,500.00	34,185,200.00
1340	**Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих**	18,899,850.00	18,902,580.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	18,899,850.00	18,902,580.00
2	**НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)**	**415,571,250.00**	**675,192,532.43**
21	**УРСГАЛ ЗАРДАЛ**	**415,571,250.00**	**675,192,532.43**
210	**БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ**	**413,192,437.45**	**642,417,132.43**
2101	**Цалин хөлс болон нэмэгдэл урамшил**	282,775,242.00	399,850,631.00
210101	Үндсэн цалин	253,344,649.00	298,210,016.00
210102	Нэмэгдэл	00.00	67,351,500.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,637,000.00	5,208,250.00
210104	Урамшуулал	18,753,593.00	24,040,865.00
210105	Гэрээт ажлын хөлс	5,040,000.00	5,040,000.00
2102	**Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл**	35,491,198.45	51,539,431.93
210201	Тэтгэврийн даатгал	24,134,099.65	39,166,305.95
210202	Тэтгэмжийн даатгал	2,839,299.83	3,124,946.40
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,271,399.88	2,500,288.31
210204	Ажилгүйдлийн даатгал	567,799.09	613,807.31
210205	Эрүүл мэндийн даатгал	5,678,600.00	6,134,083.96
2103	**Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал**	24,843,954.00	32,544,495.00
210301	Гэрэл, цахилгаан	1,825,809.00	3,179,927.00

210302	Түлш, халаалт	22,968,145.00	29,364,568.00
210303	Цэвэр, бохир ус	50,000.00	00.00
2104	**Хангамж, бараа материалын зардал**	18,374,520.00	33,173,730.00
210401	Бичиг хэрэг	1,186,100.00	2,375,900.00
210402	Тээвэр, шатахуун	13,556,700.00	20,881,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,335,220.00	1,798,030.00
210404	Ном, хэвлэл	97,500.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	999,000.00	2,924,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,200,000.00	5,194,000.00
2105	**Норматив зардал**	29,662,097.00	118,147,294.50
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	23,064,047.00	97,984,854.50
210502	Хоол, хүнс	6,598,050.00	17,362,440.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	2,800,000.00
2106	**Эд хогшил, урсгал засварын зардал**	5,373,400.00	3,979,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,190,000.00	3,155,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	464,000.00	00.00
210604	Урсгал засвар	1,719,400.00	824,600.00
2107	**Томилолт, зочны зардал**	98,000.00	192,000.00
210702	Дотоод албан томилолт	98,000.00	192,000.00
2108	**Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж**	769,326.00	658,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	230,400.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	120,000.00	216,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	54,450.00	79,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	77,500.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	00.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	264,000.00	308,000.00
210807	Газрын төлбөр	22,976.00	00.00
2109	**Бараа үйлчилгээний бусад зардал**	15,804,700.00	2,331,450.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,804,700.00	2,331,450.00
213	**УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ**	**2,378,812.55**	**32,775,400.00**
2132	**Бусад урсгал шилжүүлэг**	00.00	31,800,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	31,800,000.00
2133	**Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг**	2,378,812.55	975,400.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,378,812.55	975,400.00
3	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)**	**00.00**	**23,158,947.57**
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	**00.00**	**00.00**
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	**00.00**	**00.00**
7	**САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ**	**00.00**	**00.00**
8	**НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)**	00.00	23,158,947.57
9	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл**	00.00	00.00
10	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл**	00.00	23,158,947.57

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	**2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл**	216,844,280.85	170,888,398.31	52,128,055.56	439,860,734.71
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	**Дахин илэрхийлсэн үлдэгдэл**	**216,844,280.85**	**170,888,398.31**	**52,128,055.56**	**439,860,734.71**
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	41,005,935.87	41,005,935.87
C08	**2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл**	**216,844,280.85**	**170,888,398.31**	**93,133,991.43**	**480,866,670.58**
D01	**2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл**	**216,844,280.85**	**170,888,398.31**	**93,133,991.43**	**480,866,670.58**
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	**Дахин илэрхийлсэн үлдэгдэл**	**216,844,280.85**	**170,888,398.31**	**93,140,954.18**	**480,866,670.58**
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	640,354,226.09	640,354,226.09
D09	**2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл**	**216,844,280.85**	**162,320,484.41**	**742,056,131.42**	**1,121,220,896.67**

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

ЭЗА	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл**				
2	**НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН**	471,871,400.00	454,867,185.43	17,004,214.57	96.4%
21	**УРСГАЛ ЗАРДАЛ**	471,871,400.00	454,867,185.43	17,004,214.57	96.4%
210	**БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ**	471,871,400.00	454,867,185.43	17,004,214.57	96.4%
2101	**Цалин хөлс болон нэмэгдэл урамшил**	313,157,800.00	307,179,288.00	5,978,512.00	98.1%
210101	Үндсэн цалин	274,018,400.00	272,890,173.00	1,128,227.00	99.6%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,808,000.00	5,208,250.00	599,750.00	89.7%
210104	Урамшуулал	28,291,400.00	24,040,865.00	4,250,535.00	85.0%
210105	Гэрээт ажлын хөлс	5,040,000.00	5,040,000.00	0.00	100.0%
2102	**Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл**	42,276,300.00	40,083,169.93	2,193,130.07	94.8%
210201	Тэтгэврийн даатгал	29,750,000.00	27,710,043.95	2,039,956.05	93.1%
210202	Тэтгэмжийн даатгал	3,131,600.00	3,124,946.40	6,653.60	99.8%
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,505,200.00	2,500,288.31	4,911.69	99.8%
210204	Ажилгүйдлийн даатгал	626,300.00	613,807.31	12,492.69	98.0%
210205	Эрүүл мэндийн даатгал	6,263,200.00	6,134,083.96	129,116.04	97.9%
2103	**Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал**	32,385,200.00	32,385,200.00	0.00	100.0%
210301	Гэрэл, цахилгаан	3,000,000.00	3,179,927.00	-179,927.00	106.0%
210302	Түлш, халаалт	29,065,200.00	29,205,273.00	-140,073.00	100.5%
210303	Цэвэр, бохир ус	320,000.00	00.00	320,000.00	0.0%
2104	**Хангамж, бараа материалын зардал**	30,232,000.00	29,321,930.00	910,070.00	97.0%
210401	Бичиг хэрэг	1,500,000.00	1,477,900.00	22,100.00	98.5%
210402	Тээвэр, шатахуун	20,072,000.00	20,022,000.00	50,000.00	99.8%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,260,000.00	1,798,030.00	461,970.00	79.6%
210404	Ном, хэвлэл	100,000.00	00.00	100,000.00	0.0%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,200,000.00	2,924,000.00	276,000.00	91.4%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,100,000.00	3,100,000.00	0.00	100.0%
2105	**Норматив зардал**	39,100,000.00	38,736,047.50	363,952.50	99.1%
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	28,150,000.00	28,136,047.50	13,952.50	100.0%
210502	Хоол, хүнс	7,800,000.00	7,800,000.00	0.00	100.0%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,150,000.00	2,800,000.00	350,000.00	88.9%
2106	**Эд хогшил, урсгал засварын зардал**	7,800,000.00	3,979,600.00	3,820,400.00	51.0%
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,500,000.00	3,155,000.00	1,345,000.00	70.1%

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,500,000.00	00.00	1,500,000.00	0.0%
210604	Урсгал засвар	1,800,000.00	824,600.00	975,400.00	45.8%
2107	**Томилолт, зочны зардал**	1,150,000.00	192,000.00	958,000.00	16.7%
210702	Дотоод албан томилолт	1,150,000.00	192,000.00	958,000.00	16.7%
2108	**Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж**	1,425,800.00	658,500.00	767,300.00	46.2%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	300,000.00	00.00	300,000.00	0.0%
210802	Аудит, баталгаажуулалт, зөрэглэл тогтоох	360,000.00	216,000.00	144,000.00	60.0%
210803	Даатгалын үйлчилгээ	129,300.00	79,500.00	49,800.00	61.5%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	77,500.00	00.00	77,500.00	0.0%
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	66,000.00	55,000.00	11,000.00	83.3%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	465,000.00	308,000.00	157,000.00	66.2%
210807	Газрын төлбөр	28,000.00	00.00	28,000.00	0.0%
2109	**Бараа үйлчилгээний бусад зардал**	4,344,300.00	2,331,450.00	2,012,850.00	53.7%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,344,300.00	2,331,450.00	2,012,850.00	53.7%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	471,871,400.00	465,038,880.00	6,832,520.00	98.6%
1310	**УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ**	412,926,500.00	412,926,500.00	0.00	100.0%
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	412,926,500.00	412,926,500.00	0.00	100.0%
1320	**ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ**	34,185,200.00	33,209,800.00	975,400.00	97.1%
132001	Орон нутгийн төсвөөс	34,185,200.00	33,209,800.00	975,400.00	97.1%
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих			0.00	
1340	**НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ**	24,759,700.00	18,902,580.00	5,857,120.00	76.3%
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	24,759,700.00	18,902,580.00	5,857,120.00	76.3%
4	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл**	00.00	00.00	0.00	
5	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл**	00.00	10,171,694.57	-10,171,694.57	
62	**АЖИЛЛАГСДЫН ТОО**	24.00	24.00	0.00	100.0%
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.0%
620002	Гүйцэтгэх ажилтан	18.00	18.00	0.00	100.0%
620003	Үйлчлэх ажилтан	04.00	04.00	0.00	100.0%
620004	Гэрээт ажилтан	01.00	01.00	0.00	100.0%

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	**НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН**		**219,349,947.00**
21	**УРСГАЛ ЗАРДАЛ**		**219,349,947.00**
210	**БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ**		187,549,947.00
2101	**Цалин хөлс болон нэмэгдэл урамшил**		92,671,343.00
210101	Үндсэн цалин		25,319,843.00
210102	Нэмэгдэл		67,351,500.00
2102	**Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл**		11,456,262.00
210201	Тэтгэврийн даатгал		11,456,262.00
2103	**Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал**		159,295.00
210302	Түлш, халаалт		159,295.00
2104	**Хангамж, бараа материалын зардал**		3,851,800.00
210401	Бичиг хэрэг		898,000.00
210402	Тээвэр, шатахуун		859,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		2,094,000.00
2105	**Норматив зардал**		79,411,247.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		69,848,807.00
210502	Хоол, хүнс		9,562,440.00
213	**УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ**		31800000.00
2132	**Бусад урсгал шилжүүлэг**		31,800,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		31,800,000.00
II	**ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР**		232337200.00
1311	**Нэмэлт санхүүжилтийн орлого**		232,337,200.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		9,389,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		31,800,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		191,148,200.00
IV	**НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)**		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		12,987,253.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Сагил сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Амармэнд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Сагил сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сагил сумын Эрүүл мэндийн төв нь Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулж үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг явуулдаг байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас Сагил сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сагил сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьиар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 3,541.0 мянган төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 699,389.3 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 6,993.8 мянган төгрөгийн 80 хувиар буюу 5,595.1 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлан гарах цагалбарт хугацаа болоогүй байсан тул материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар дахин шинэчлэн тогтоосон.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сагил сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 170,922.9 мянган төгрөгөөр буюу 28.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		23,158.9	23,158.9
Авлага	493.0	160,069.1	159,576.1
Бараа материал	20,253.4	40,749.6	20,496.2
Үндсэн хөрөнгө	460,282.4	897,545.4	437,263.0
Нийт хөрөнгө	481,028.8	1,121,523.1	640,494.3
Өр төлбөр	162.2	302.2	140.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	480,866.6	1,121,220.8	640,354.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	481,028.8	1,121,523.1	640,494.3

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 23,158.9 мянган төгрөг болж 23,158.9 мянган төгрөгөөр өссөн нь үлдэгдэл төвлөрүүлээгүйгээс шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэл 160,069.1 мянган төгрөг болж 159,576.1 мянган төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилт дутуу ирснээс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 40,749.6 мянган төгрөг болж 20,496.2 мянган төгрөгөөр өссөн нь Ковид-19 цар тахлаас шалтгаалан аж ахуйн материал, эм боох

материал нэмэгдсэнээс шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Оны эцэст бараа материалын нөөц үүсгэсэн нь ирэх онд Ковид-19 цар тахалд зарцуулахаар байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 897,545.4 мянган төгрөг болж 437,263.0 мянган төгрөгөөр өссөн нь худалдан авсан болон үнэ төлбөргүй авсан хөрөнгө нэмэгдсэнээс шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн дансанд урсгал төсвийн худалдан авалтаар 3,155.0 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 479,010.9 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгөөс акталж устгасан 1,839.4 мянга, худалдсан 838.0 мянга, балансаас баланст шилжүүлсэн 29,351.8 мянга, нийт 32,029.2 мянган төгрөгийн хөрөнгө хасагдсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,121,220.8 мянган төгрөг болж 640,354.2 мянган төгрөгөөр өссөн нь шинээр нэмэгдсэн үндсэн хөрөнгө, тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 865,054.1 мянган төгрөгөөр буюу 178.9 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээж авсан орлого, нэмэлт санхүүжилтийн орлого, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих орлого байна. Энэ нь Ковид-19 цар тахалтай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 256,759.1 мянган төгрөгөөр буюу 58 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан цалин, НДШ, байр ашиглалттай холбоотой зардал, хангамжийн бараа материалын зардал, норматив зардал, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл зэрэг зардлууд байна. Энэ нь ковид-19 цар тахалтай холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга 6.9 мянган төгрөгөөр хийгдсэн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 418,755.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 418,755.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 52,472.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 471,227.5 мянган төгрөгөөр баталсныг төсвийн тодотгол хийж 643.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 471,871.4 мянган төгрөгөөр баталсан байна

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 471,871.4 мянган төгрөгийн төсөв баталснаас 412,926.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 34,185.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 24,759.7 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 412,926.5 мянга, орон нутгийн төсвөөс 34,185.2 мянга, эрүүл мэндийн даатгалын сангаас 18,902.5 мянга, нийт 466,014.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 454,867.1 мянган төгрөгийг зарцуулж 975.4 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 23,158.9 мянган төгрөг байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 454,867.1 мянган төгрөг буюу 96.4 хувьтай байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан 31,800.0 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 191,148.2 мянга, хандив, тусламжийн 9,389.0 мянга нийт 232,337.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс урамшууллын зардалд 92,349.9 мянга, НДШ зардалд 11,456.2 мянга, түлш халаалтын зардалд 159.2 мянга, хангамж, бараа материалын зардалд 3,851.8 мянга, нормативт зардалд 79,411.2 мянга, нэг удаагийн тэтгэмжийн зардалд 31,800.0 мянга, нийт 219,349.9 мянган төгрөгийг зарцуулсан байна. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд 12,987.3 мянган төгрөг байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Сагил сумын Эрүүл мэндийн төвийн хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй

байсан тул Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх нийцлийн аудитаар шалгахаар шийдвэрлэв.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 120, хугацаа хоцроож мэдээлсэн 29 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сагил сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайланд Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих төлбөрт үйлчилгээний орлогын 160,092.5 мянган төгрөгийн авлага тусгагдсан байна. 2022 оны 1 дүгээр сард санхүүжилтийг олгосон байна. Дараагийн аудитаар тухайн авлагын зарцуулалтыг нарийвчлан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 73,405.5 мянган төгрөгийн 4 алдаа зөрчил илэрснээс, 23,148.3 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 657.2 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 49,600.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасныг зөрчин шуудан холбоо, нэг удаагийн тэтгэмж шагнал урамшууллын зардлыг шууд зардалд бүртгэсэн 23,148.3 мянган төгрөгийн алдаа зөрчлийг залруулаа.

4.2 Төлбөрийн акт

1. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулна", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" 13.7 дахь хэсэгт "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 зүйлийн 20.1.4 заалтад "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", 20.2.5 дахь заалтад "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг зөрчин ажилтнаас суутгах сахилгын шийтгэлийн суутгал 162.2 мянган төгрөгийн өглөгийг цалингийн зардлаас шилжүүлснийг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.
2. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулна", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь хэсэгт "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7 дахь хэсэгт "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг

хориглоно" гэж заасныг зөрчин хүнсний материалын тооллогоор дутагдсан 495.0 мянган төгрөгийн 55 кг махны үнийг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Мөнгөн урамшуулалтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Сагил сумын Эрүүл мэндийн төв нь Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны 377/А99 дүгээр тушаалыг зөрчин Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг үндэслэн Ковид-19 цар тахлын холбогдуулан олгосон санхүүжилтээс 49,600.0 мянган төгрөгийн мөнгөн тэтгэмж олгосон байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны 377/А99 дүгээр тушаалыг хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сагил сумын Эрүүл мэндийн төв	4	73,405.5	1	23,148.3	2	657.2			1	49,600.0

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН: АУДИТОР /Т.АМАРМЭНД/

2022 оны 02 сарын 25-ны өдөр